



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/101

Хажуу шинэ ус

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1, 48.2.4, 48.2.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.3 дахь хэсэг, 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 04 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “ЗДТГазрын нийтийн бие засах газрыг шинэчилж шинэ 00” хийх ажил 4,992,000.00 (Дөрвөн сая есөн зуун ерэн хоёр мянга) төгрөгийн үнийн санал ирүүлсэн Б.Мягмарсүрэн ахлагчтай “Хасу” иргэний бүлэгтэй шууд гэрээ байгуулах эрхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д олгосугай.

2 “ЗДТГазрын нийтийн бие засах газрыг шинэчилж шинэ 00” хийх ажлыг захиалагчийн гаргасан саналд үндэслэн чанар сайтай хийж гүйцэтгэхийг “Хасу” иргэний бүлгийн ахлагч (Б.Мягмарсүрэн)-д даалгасугай.

3. Б.Мягмарсүрэнтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын явцад гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох), Санхүү албаны дарга (Н.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Т.АРИУНАА

482401101